



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**АЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ХУЯГБААТАРЫН
МӨНХСАРНАЙ ТАНАА**

2020.09.03 № 077-2020/06-НА 55
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Хуягбаатарын Мөнхсарнайгийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Х.Мөнхсарнай нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020770

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Х.Мөнхсарнайгийн Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Х.Мөнхсарнайгийн мөрийн хөтөлбөр /.....^L хуудас/-ийг хавсаргав.


Хувийг: Алтанбулаг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН 2020 ОНЫ ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ХУЯГБААТАРЫН МӨНХСАРНАЙГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



Уриа: Төр, иргэд хоорондын эргэх холбоог сайжруулж, төрөлх нутгаа хөгжүүлэхэд
иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛ - ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- 1.1. Алтанбулаг суманд цахим орчин вэб сайттай болж, цахим сургалт нэвтрүүлэн, төрийн үйлчилгээ болон үйл ажиллагааг иргэдэд нээлттэй болгох чиглэлээр ажиллана.
- 1.2. Баг, сум хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөлтийг иргэдээр хэлэлцүүлэн, жил бүрийн үндсэн чиглэлд оруулан баталгаажуулж, дэс дараатайгаар хэрэгжүүлнэ.
- 1.3. Гэр хорооллуудыг кабелийн телевизтэй болгох, залуучуудын соёл амралтын газруудад үнэгүй WiFi төхөөрөмж байршуулах боломж, нөхцөлийг судлан, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.4. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлан мал бүхий иргэдийн малын бэлчээрийг нэмэгдүүлэх, хадлангийн талбайтай болохыг дэмжинэ.


ДЭД БҮТЭЦ - ХӨГЖЛИЙН ҮҮД:

- 2.1 Сумын төвийн хорооллын замыг сайжруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.2 Цэвэр усны хүртээмжийг сайжруулахын тулд гүний худгийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр санал, санаачилга гаргаж, шийдвэрлүүлнэ.
- 2.3 Суманд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах замаар тохижилт үйлчилгээ, хогны асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.
- 2.4 Сумын төв дагуу хороолол, баг хэсгүүдийн дунд тохижилтын аяныг иргэдийн санал санаачилгад тулгуурлан зохион байгуулна.
- 2.5 Сумын төвийн тохижилтыг сайжруулах, явган хүний замтай болгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

ӨРХИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ - ЧАНАРТАЙ АМЬДРАЛ

- 3.1 Ард иргэдийн өрхийн аж ахуйг дэмжсэн төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, өвөл зуны хүлэмжтэй болох, зоорины аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

- 3.2 Хүүхдийн өвчлөлийг бууруулах, иргэдийг эрүүлжүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх бодлогын хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг эхлүүлнэ.



АЮУЛГҮЙ ТАЙВАН - АМГАЛАН НИЙГЭМ

- 4.1 Ахмад үеийн мэдлэг чадвар, туршлагыг хойч үеийнхэнд өвлүүлэх, суралцуулах зорилгоор “Ахмадын хороо”-той хамтран ажиллана.
- 4.2 Архи согтуурах ундааны хэрэглээг хязгаарлах үүднээс сум, баг, байгууллага хамт олноороо архигүй хамт олон болох уриаг дэвшүүлэн ажиллана.

БОЛОВСРОЛ - БИДНИЙ ХӨГЖИЛ

- 5.1 Орон нутгийн хүүхэд залуучуудад сургалтын өдөртэй болгох санал, санаачилга гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 5.2 ЕБС болон СӨБ-ийн багшийн хөгжлийг дэмжих “Багш –Эцэг эх” хөтөлбөрийг санаачлан зохион байгуулна.

НЭР ДЭВШИГЧ:

Х.МӨНХСАРНАЙ

2020 оны 07-р сарын 24